




Co-funded by the
Erasmus+ Programme
of the European Union



**ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛЫН
НЭР ТОМЬЁНЫ
МОНГОЛ-АНГЛИ ТАЙЛБАР ТОЛЬ**

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛЬ

**ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛЫН
НЭР ТОМЬЁОНЫ
МОНГОЛ-АНГЛИ ТАЙЛБАР ТОЛЬ**

УЛААНБААТАР ХОТ
2022 ОН

ННА 74,58
ДАА 378
О-19

**ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛЫН НЭР ТОМЬЁНЫ
МОНГОЛ-АНГЛИ ТАЙЛБАР ТОЛЬ**

Боловсруулсан: Д.Одгэрэл (Ph.D)
Хянасан: Д. Наранцэцэг (Ph.D), профессор

Copyright @ Энэхүү бүтээл нь Монгол улсын зохиогчийн эрхийн тухай хуулиар баталгаажсан тул эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр хэсэгчлэн болон бүтнээр нь дахин хэвлэх, цахим болон бусад хэлбэрээр хувилан олшруулах, түгээн тараахыг хориглоно.

Цаасны хэмжээ: 143*205
Хэвлэлийн хуудас: 4,0хх
Адмон принт ХХК-д эхийг бэлтгэж хэвлэв.
ISBN 978-9919-26-674-5

ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛЫН НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР ТОЛЬ БИЧГИЙН ТУХАЙД

2015 онд Солонгос улсын Инчеон хотноо болсон Дэлхийн Боловсролын чуулга уулзалтаас “Тэгш хамарсан, тэгш боломжийг баталгаажуулсан бүх нийтийн чанартай боловсролыг насан туршид нь эзэмшүүлэх” эрхэм зорилгыг дэвшүүлсэн билээ.

Энэхүү эрхэм зорилгыг хэрэгжүүлэхийн төлөө улс орон бүр боловсролын тогтолцоогоо сайжруулан, хүүхэд бүрийн онцлог, хэрэгцээг харгалзан бүрэн чадамжаар нь хөгжүүлэхийг зорьж байна.

Хүүхэд бүрийн боловсролын хэрэгцээ, хөгжих орчин, суралцах үйл ажиллагаанд хамаарал бүхий үг хэллэг ойлгомжтой, оновчтой байх нь хүүхдийн хөгжлийг бодитоор дэмжихэд бүрэн тусгалаа олж, хувь хүний болон нийгмийн хөгжилд чухал ач холбогдолтой юм.

Монгол улсад “Тусгай боловсрол” болон “Тэгш хамруулан сургах боловсрол”-ын чиглэлээр цөөнгүй ном, сурах бичиг, зөвлөмж, товхимол, эрх зүйн баримт бичгүүд шат шатандаа боловсруулагдан гарсан хэдий ч, эдгээрийн агуулга концепц тодорхой бус, нэр томьёоны талаар мэргэжлийн хүмүүс, багш, эцэг эхчүүдийн дунд ойлголт өөр өөр байгааг судалгааны үр дүн харуулж байна (IRIM, 2019).

Энэхүү тайлбар толь бичиг нь:

- Хөгжингүй улс орнуудын боловсролын хууль, эрх зүйн баримт бичиг, тайлбар толь бичиг

зэрэгт тусгагдсан тэгш хамруулан сургах боловсролын нэр томьёо, үг хэллэгийг орчин үеийн чиг хандлагын үүднээс авч үзэж, тайлбарласан.

- Боловсролын салбарт хамааралтай хүн бүрийг (оюутан, багш, сэтгэл зүйч, эцэг эх, асран хамгаалагч, судлаач, мэргэжилтэн гэх мэт) нэгдмэл ойлголттой болгоход чиглүүлэг болно.

Эрхэм хэрэглэгч та энэхүү толь бичгийг ашигласнаар “Тэгш хамруулан сургах боловсрол”-ын талаар шинжлэх ухааны үндэстэй нэгдмэл ойлголттой болж, улмаар хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулахад үнэтэй хувь нэмрээ оруулна гэдэгт итгэж байна.

Дандийн Одгэрэл (Ph.D)

A

1. Анагаахын /эрүүл мэндийн загвар, хандлага

Тухайн хүний хөгжлийн онцлог, тусгай хэрэгцээг “өвчин, согог” талаас авч үзэж, түүнийг засаж эмчлэх чиглэлийг баримтлах хандлага юм. Анагаахын буюу эрүүл мэндийн загварыг боловсролын салбарт ашиглаж ирсэн хэдий ч, орчин үед боловсролын салбар нь “согог”-ийг онцлох анагаахын загвараас татгалзаж, тухайн хүний нийгмийн харилцан үйлдлийн үр дүн болох нийгмийн загвар (social model)-ыг авч хэрэгжүүлж байна. Боловсролын үйлчилгээ нь “согог”-ийг засаж эмчлэх бус хэрэгцээнд нь нийцсэн, тохирсон боловсрол олгох замаар нийгмийн амьдралд үр дүнтэй оролцох боломжийг нэмэгдүүлэх явдал юм.

Medical model, approach

It is a tendency to look at a person’s developmental characteristics and special needs from the point of view of “diseases or impairment” and to treat them. Although the medical model has been used in the education sector, today the education sector has abandoned the medical model that emphasizes on “defects” and adopted a social model of individual social interaction. Education services are not about correcting “defects” but about increasing opportunities for persons with special needs to participate effectively in society by providing education that meets their needs.

- 2. Ангилал** гэдэг бол аливаа юмсын хэв шинжийг ихэвчлэн тодорхой бүтцэд оруулсан нэгдмэл систем, тогтолцоог хэлнэ. Тус систем нь амьдралд хэрэглэгдэхүйц хэмжээнд байхын тулд 4 шалгуурыг хангасан байх шаардлагатай. Үүнд:
- Үнэн зөв, баталгаажсан байх
 - Хүчин төгөлдөр бүх шинжүүдийг өөртөө шингээсэн байх
 - Логик зүй тогтлын байнгын уялдаа холбоотой байх
 - Байнга шинэчлэгдэх

A **classification** is an integrated system in which the nature of things is usually structured. In order for the system to be viable, it must meet four criteria.

- Must be accurate and verified
- Must have all valid characteristics
- There should be a logical constant connection
- Must be updated regularly

3. Анхаарлын дутмагшил, хэт хөдөлгөөнтөх эмгэг (АДХХЭ)

Анхаарлаа төвлөрүүлж чадахгүй байх, хэт хөдөлгөөнтэй байх хэв шинжүүд нь 6-аас доошгүй сар үргэлжилсэн. Эдгээр шинжүүд нь тухайн хүүхдийн сурлага, хүмүүжилд ноцтой саад, бэрхшээл болж байвал тусгай боловсролын үйлчилгээ авах нэг ангилал болгон авч үзнэ.

Attention Deficit, Hyperactivity Disorder (ADHD)

If an inability to concentrate and hyperactivity lasts for at least 6 months, and these symptoms are adversely affecting child's educational performance is considered as one of the categories of disability.

4. АДХХЭ-ийн үнэлгээ

Дараах шалгуурт тохирч байгаа тохиолдолд боловсрол, сэтгэл судлал, эмнэл зүйн талаас нарийн судалгаа хийх шаардлагатай. "Анхаарлын дутмагшил", "Хэт хөдөлгөөнтөх", "Бодлогогүй үйлдэл" гэсэн 3 ангилал тус бүрийн "шинжүүд"-ийг илрүүлэх доорх асуултууд байдаг.

Анхаарлын дутмагшил

- Хичээл сургалтын үед нарийн жижиг зүйлүүдэд анхаарлаа хандуулаагүйгээс шалтгаалсан алдаа их гаргагадаг
- Ямар нэгэн үйлийг гүйцэтгэх, тоглох зэрэг үед тухайн зүйлд анхаарлаа удаан төвлөрүүлж чаддаггүй
- Хичээл болон ямар нэг зүйлийг дэс дарааллын дагуу хийж чаддаггүй. Анхаарлаа төвлөрүүлэн сууж хичээл зүтгэл гаргахаас зайлсхийдэг /дургүй/
- Хичээл сургалтын явцад хэрэгтэй зүйлүүдээ гээж үрэгдүүлдэг. Анхаарал нь амархан сарнидаг, мартагхай.

Хэт хөдөлгөөнтөх

- Гар хөлөө байнга савчиж, ямар ч нөхцөлд тогтворгүй, үргэлжийн хөдөлгөөнтэй байдаг, хичээлийн дундуур босч явдаг. Урдаас нь хараад ярих үед яриаг сонсохгүй байгаа мэт санагдах
- Чөлөөт цаг, тоглоомын үйл ажиллагаанд тайван, тогтвортой оролцож чаддаггүй
- Зүгээр байж чаддаггүй. Хэт их ярьдаг
Бодлогогүй үйлдэл
- Асуулт асууж дуусаагүй байхад дундуур нь хариулдаг
- Ээлж дараалал хүлээж чаддаггүй

- Бусдын хийж байгаа зүйлд саад болж, тасалдуулдаг

Assessment of ADHD

If the below mentioned criteria are met, a study of the child from educational, psychological, and medical points are required. The symptoms below correspond to the questions in each category, such as “lack of attention”, “hyperactivity”, and “impulsive behavior”, and these symptoms may last for more than 6 months.

Attention Deficit Disorder:

- During the classes is inattentive, making a lot of mistakes without paying attention to the details.
- When doing or playing with something, can't focus on it for long.
- Don't seem to be listening while someone talk and look at him (her).
- Don't follow the instructions, can't do anything till the end.
- While doing lesson assignments or something else, can't do it in order, can't make order and can't stay focused and avoids hard work (doesn't like it)
- They lose their stuff, what they need during class.
- Easily get distracted, forgetful.

Hyperactive

- The arms and legs are constantly swaying, and even when sitting, overactive moving all the time
- Leaves seat in classroom or in other situations in which remaining seated is expected.
- They run, jump, and climb in inadequate conditions. Can't participate in leisure and play activities in a calm and stable way. Can't stay without doing anything. Talks too much. Reckless action. Can't wait his (her) turn. When a question is not finished,

interrupting with answer. Interrupts what others are doing and makes trouble.

5. Анги танхимын зохион байгуулалт

Багшийн зүгээс хичээл сургалтыг тасралтгүй явуулахад зан үйлийн асуудал гаргаж болзошгүй байдлаас үл хамааран сургалтыг зохион байгуулах, сурагчдын сурах нөхцөлийг хангах үйл явц.

Classroom management

This is a term teacher use to describe the process of ensuring that classroom lessons run smoothly without disruptive behavior from students compromising the delivery of instruction.

6. Аутизмын хүрээний эмгэг

Хүний үгэн болон үгэн бус харилцаа, нийгмийн харилцан үйлчлэл хэт хязгаарлагдмал сонирхол болон дахин давтагдсан зан үйлээр илэрдэг хөгжлийн эмгэг. Аутизм Спектрум гэдэг нь англи хэлний солонгорсон залгаа, холбоотой бүрэлдэхүүн гэсэн утгатай үг. Аутизмын хүрээний эмгэгийг (1) Нийгэмшихүйн бэрхшээл, (2) Харилцааны бэрхшээл, (3) Төсөөлөн бодох чадвар, хэвшмэл, давтагдсан зан үйлийн бэрхшээл гэсэн 3 гол шинж тэмдгээр нь тодорхойлж болно.

ASD - Autism Spectrum Disorder

A developmental disorder characterized by excessive verbal and non-verbal communication, limited social interest, and repetitive behaviors. "Spectrum" is in English meaning an adjoining like a rainbow, related components. Autism spectrum disorders can be defined

by three main symptoms: (1) Social problems, (2) Communication problems, (3) Imagination, stereotypes, and recurring behavioral problems.

7. **Аспергерийн синдром**

Аутизмын хүрээний эмгэгийн нэг төрөл. Оюуны чадавх хэвийн, эсвэл өндөр, мөн хүмүүстэй харилцах буюу нийгэмшихүйн чадварын асуудалтай байдаг.

Asperger syndrome

One of the types of ASD that affect ability to communicate with people, have high or average intellectual ability.

8. **Аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдэд дэмжлэг үзүүлэх арга зүй**

Харилцах арга: Аутизмын хүрээний эмгэгтэй хүн бусдын яриаг сонсоод ойлгох чадвар сул байдаг тул ямар нэгэн зүйл хэлж, тайлбарлах үедээ зөвхөн хэл яриагаар биш, бусад харилцааны аргуудыг ашиглах нь үр дүнтэй байдаг. Аутизмын хүрээний эмгэгтэй хүний харааны хүртэхүй сайн хөгжсөн байдаг тул бодит зүйлийг үзүүлэх, зураг харуулах, бичиж тайлбарлах зэрэг аргыг ашиглана.

Аливаа өөрчлөлтийг урьдчилж мэдэгдэх: Аутизмын хүрээний эмгэгтэй хүн төлөвлөгөө өөрчлөгдөх, шинэ орчин нөхцөлд орох зэрэг гэнэтийн зүйлд тавгүйтэж, тайван бус болдог. Тэд тухайн өдөр, хэдэн цагт, юу хийх вэ гэдгийг урьдчилан мэдэж байвал тайван байж чаддаг. Тиймээс төлөвлөгөө өөрчлөгдөх, шинэ зүйл хийх гэх мэт үед урьдчилан мэдэгдэж, тэдэнд дасан зохицох хангалттай хугацаа өгч байх хэрэгтэй. Ингэхдээ хүүхдийн онцлогт тохируулж бичгээр болон

зургаар тайлбарлаж ойлгуулж болно.

Анхаарал төвлөрөх орчин бүрдүүлэх: Аутизмийн хүрээний эмгэгтэй хүүхэд дуу чимээнд ихээхэн мэдрэмтгий байдаг тул дуу чимээ ихтэй, олон хүнтэй газарт дургүй байх нь олон. Дуу чимээ ихтэй, үзэгдэх зүйл олон байх тусам сэтгэл, санааны байдал нь тогтворгүй, анхаарал сарних нөхцөл бий болно. Тиймээс суух суудал, үзэгдэх орчин, хичээллэх арга барилд ихээхэн анхаарал хандуулах хэрэгтэй. *Тайвнаар харилцах:* Өндөр дуугаар ярих, тэгж болохгүй гэж чанга ширүүн хэлэх үед аутизмтай хүн тухайн хүнийг уурлаж байна гэж бодон, уурлаж байгаагаас өөрөөр хүлээн авахгүй болчихдог. Тиймээс, анхнаасаа тайван тогтуун ярилцаж, ойлгуулж байх хэрэгтэй.

Methods of supporting children with autism spectrum disorder (ASD)

Communication methods: Because people with autism have poor listening and comprehension skills, it is effective to use other than verbal, when saying or explaining something communication methods. People with autism have well-developed visual perception skills, it is suggested to use authentic stuff, pictures, and written descriptions. It is suggested to notify in advance, if there is any changes is predicted.

To inform about any changes in advance: People with autism often feel anxious and restless about unexpected things, such as changing plans or moving to a new environment. They can be calm if they know in advance what day, what time, and what they will do. So being aware of changes in plans, new things, and so on, and giving them enough time to adjust makes them to avoid

worries. This can be done in writing or illustrating about plans.

Creating an environment where the child can concentrate: Children with autism are sensitive to noise, so they are more likely to dislike loud noise and crowded places. The louder the noise and the visibility area is crowded, the child become more unstable and distracted. Therefore, attention should be paid to seating place, visibility area, and training methods. *Communicating calmly:* When speaking out loud and shouting, a person with autism may feel that the person is angry and will not accept anything other than the speaker is being angry. Therefore, from the beginning, we need to talk calmly and understandably.

9. Аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдийг дэмжих арга зүй (ТЕАССН)

ТЕАССН аргыг аутизмын хүрээний эмгэгтэй (ASD) хүмүүст туслахад үр дүнтэй, нэгдмэл арга зүйн шийдэл хэмээн боловсруулсан. ТЕАССН нь аутизмтай хүмүүсийн харааны хүртэхүй дээр суурилсан сургалтын хөтөлбөр тул багш нар үйл ажиллагааны стратеги арга зүйгээ тохируулан өөрчлөх ёстой. ТЕАССН нь үндсэн таван зарчим дээр тулгуурладаг. Нэгдүгээрт, ахуй орчин нь тухайн хүний хүрээлж буй сургалтын нэг талбар болдог. Тоглох, идэх гэх мэт өдөр тутмын үйл ажиллагаа нь маш тодорхой зохион байгуулагдсан тохиолдолд сайн үр дүнтэй туршлага болдог. Хоёрдугаарт, зураг, гэрэл зураг гэх мэт янз бүрийн дүрс хэрэгслээр дамжуулан тогтмол хуваарийг дагаж мөрдөх нь үр дүнтэй. Гуравдугаарт, тогтмол голдрилоор хийдэг үйл, үйлдэл нь бие даасан байдлыг хэмжих, дэмжих үйл

ажиллагаа болдог. Дөрөвдүгээрт, тууштай байдал ба тогтмол зааварчилгаа нь аутизмтай хүмүүсийн хувьд хамгийн чухал дэмжлэг болдог. Тавдугаарт, харааны хүртэхүүд суурилсан дохио, сануулга, зааварчилгаа нь дэмжлэгийн хамгийн тохиромжтой арга болдог.

TEACCH method to support children with autism spectrum disorder

TEACCH (Treatment and Education of Autistic and Communication Handicapped Children) method was developed by researchers who wanted a more effective and integrated approach to helping individuals with autism spectrum disorders (ASD). TEACCH is an evidence-based academic program that is based on the idea that autistic individuals are visual learners, so teachers must correspondingly adapt their teaching style and intervention strategies. TEACCH is centered on five basic principles. First, physical structure refers to individual's immediate surroundings. Daily activities, such as playing and eating, work best when they are clearly defined by physical boundaries. Second, having a consistent schedule is possible through various mediums, such as drawings and photographs. Third, the work system establishes expectations and activity measurements that promote independence. Fourth, routine is essential because the most important functional support for autistic individuals is consistency. Fifth, visual structure involves visually-based cues for reminders and instruction.

10. Ахуй засалч

Хоол бэлтгэх болоод цэвэрлэгээ, хөдөлгөөн (алхах, гишгэх, ариун цэврийн өрөө орох), ахуйн эмх цэгц

(хувцас солих, эвхэх, тоглоомоо хураах гэх мэт), тээврийн хэрэгсэлээр зорчих (автобус, галт тэрэг гэх мэт), эмийг зааврын дагуу уух гэх мэт энгийн дадал хэвшилд сургаж, хувь хүний өдөр тутмын ахуйн гүйцэтгэлийн чадварыг нэмэгдүүлэхийн тулд сэтгэц болон бие махбодын зорилгот үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг мэргэжилтэн.

Occupational therapist

A trainer or specialist that assists in everyday living: cooking and cleaning, movement (walking, walking, going to the bathroom), housekeeping (dressing, folding, picking up toys, etc.), transportation (bus, train, etc.), taking medication as directed, purposeful mental and physical activities prescribed by medical doctors to enhance individuals' abilities to perform daily occupational roles.

Б

11. Бие даах чадвар

Бусадтай харилцах, үүрэг хариуцлагаа биелүүлэх, өөрийн бурууг хүлээн зөвшөөрөх, хүнд хууртагдахгүй, дүрэм журмыг сахих, өөрийн биеэ хамгаалах гэх мэт чадваруудыг багтаадаг.

Self-care skills

It includes the ability to communicate with others, to fulfill one's responsibilities, to admit own's guilt, not to be deceived, to follow the rules, and to protect oneself.

12. Брайл үсэг, цагаан толгой

Луй Брайл гэдэг зохиогчийнхоо нэрээр нэрлэгдсэн 6 товгор цэгээр үсэг, тоо зэргийг илэрхийлдэг систем бөгөөд самбар шивүүр, бичгийн машин болон хэвлэх машин ашиглан цэглэн бичдэг бичиг. Тоолохдоо зүүн талын дээд цэгээс эхлэн тоолох ба доош нь цувуулж тоолно (1, 2,3), баруун дээд талаас (4,5,6) үргэлжлүүлэн тоолно. Монгол Брайл цагаан толгой 35 үсэгтэй.

Braille letter, alphabet

It's a system of letters and numbers in six dots named after the author's Louis Braille name, written in dots using typewriters and printers. Count from the top left count (1,2,3), down, and continue counting from the top right (4,5,6) to down. Mongolian Braille alphabet has 35 letters.

13. Бүх нийтийн боловсрол

ЮНЕСКО (НУБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага) тэргүүтэй дэлхий нийтийн "бүх нийтийн боловсрол"-ын хөдөлгөөн. ЮНЕСКО-гийн зүгээс хөдөлгөөнийг удирдах, бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх олон улсын хүчин чармайлтыг зохицуулах үүрэг хүлээсэн. Засгийн газрууд, хөгжлийн агентлагууд, иргэний нийгэм, төрийн бус байгууллагууд, хэвлэл мэдээлэл нь эдгээр зорилгод хүрэхийн төлөө ажиллаж буй зарим түншүүд юм.

Education for All

The global universal education movement, led by UNESCO (United Nations Educational, Scientific and Cultural Organization). UNESCO is committed to coordinating international efforts to lead the movement and improve universal education. Governments, development

agencies, civil society, NGOs, and the media are some of the partners working to achieve these goals.

14. Боловсролын үнэлгээ

Боловсролын үнэлгээ нь сурагчийн суралцахуй болон хөтөлбөрийг сайжруулах, зорилгоор мэдлэг, чадвар, хандлага, итгэл үнэмшлийн талаарх эмпирик өгөгдлийг баримтжуулах, ашиглах үйл явц юм. Үнэлгээний мэдээллийг сургалтын үр дүн, амжилт, сурагчийн гүйцэтгэлийг шууд шалгах аргаар эсвэл суралцах талаарх санал дүгнэлт гаргаж болох өгөгдөл дээр үндэслэн авах боломжтой.

Educational assessment

Educational assessment is the systematic process of documenting and using empirical data on the knowledge, skill, attitudes and beliefs to refine programs and improve student learning. Assessment data can be obtained from directly examining student work to assess the achievement of learning outcomes or can be based on data from which one can make inferences about learning.

15. Бэрхшээл

Энэ ухагдахуун нь нийгмийн орчин, харилцаанаас үүдэлтэй тул хувь хүний, нийгэмшихүйн үйл ажиллагааны хүрээнд авч үзэх бөгөөд нийгмийн хамгааллын, халамжийн үйлчилгээ үзүүлэхэд хэрэглэгдэх нэр томъёо.

Handicap

Terms used in the provision of social protection and welfare services, as they arise from the social environment and relationships, are considered in the context of individual and social activities

В

16. Варнокын тайлан

Варнокийн тайлан нь 1978 онд Британийн боловсролын комиссоос бэлтгэсэн боловсролын тусгай хэрэгцээтэй суралцагчдын тухай баримт бичиг юм. Энэхүү баримт бичгийн үзэл санааны ихэнх хэсэг нь Британийн тусгай боловсролын загварт үндэслэсэн болно.

Боловсролын гүн ухаанаар мэргэшсэн Британийн философич Хелен Мэри Варнокын нэрээр нэрлэсэн.

Warnock report

The Warnock report is a document prepared by the British Education Commission in 1978 referring to the special educational needs of children. This writing is based for the most part on the British special education model.

17. Векслерийн оюун ухааны хүүхдэд зориулсан сорил

Сурагчийн оюун ухааныг олон чиглэлээр хэмждэг, хэл шинжлэл, орон зайн оюун ухаан г.м. ганцаарчилсан оюун ухааны сорил юм. АНУ-д хийгдсэн стандартчилах судалгаагаар дундаж норм хэм хэмжээг тогтоон, статистикийн боловсруулалтаар найдварын зэрэг болон тохироц чанар нь ач холбогдолтой гэсэн утгыг илэрхийлсэн.

Wechsler Intelligence Scale for Children (WISC)

An individual intelligence test, which measures a student's intelligence in a variety of areas, including linguistic and spatial intelligence. This is a norm-referenced test, meaning that it has statistical validity and reliability for what it states it measures is standardization research.



18. Ганцаарчилсан (хувь хүний) сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр

Тусгайлан дэмжих шаардлагатай сурагчийн хөгжлийн онцлог, хэрэгцээ, төлөв байдлыг үнэлэн тогтоож, урт, богино хугацааны зорилго, зорилтууд, сургалтын агуулга, багшийн дэмжлэг, арга зүй зэргийн төлөвлөлт, хэрэгжилт, явцын болон эцсийн үнэлгээ хийх үйл ажиллагаануудыг тусгасан төлөвлөгөө, хөтөлбөр юм.

Individual Educational plan, program

It is a plan or program that based on assessment specific needs, and attitudes, of those who needs special support. It's integrates long-term and short- term goals and objectives, curriculum, teacher's support and strategy planning, implementation, and formative and summative assessment activities.

19. Ганцаарчилсан сургалтын хөтөлбөрийн баг

Мэргэшсэн мэргэжлийн баг нь эцэг эх, тусгай боловсролын багш, үнэлгээний мэдээлэл тайлбарлагч, ерөнхий боловсролын багш, сургуулийн удирдлага зэрэг хүмүүсээс бүрдэнэ. Тус мэргэжлийн баг нь тусгай хэрэгцээтэй хүүхдийн сургалтын хөтөлбөр, үйлчилгээ үзүүлэх зэрэгтэй холбоотой бүх шийдвэрийг гаргадаг.

Individual education program team

The team of qualified professionals made up of the parent, special education teacher, interpreter of test and assessment data and general education teacher, school administration representative at a minimum. This

group makes all decisions related to the instructional program of a child with special needs, including placement and services provided.

20. Ганцаарчилсан гэр бүлийн хөтөлбөр, төлөвлөгөө

0-3 насны тусгай хэрэгцээтэй хүүхдүүдэд эрт үеийн дэмжлэг үзүүлэх тогтолцоо. Гэр бүлд суурилсан хэрэгцээг тодорхойлж төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлдэг.

Individualized family service plan, program

A process of providing early intervention services for children ages 0-3 with special needs. Family based needs are identified and a written support plan is developed.

21. Гоц авьяастай хүүхэд

Гоц авьяастай хүүхэд оюун ухааны өндөр түвшний чадвартай эсвэл тодорхой нэг чиглэлээр онц гойд байдаг. Ихэнх улс орнууд хүүхдийн IQ-ийн оноо 130 буюу түүнээс дээш байвал гоц авьяастай гэж үздэг. Гэсэн хэдий ч гоц авьяастай хүүхэд хэл яриа, математик, урлаг, хөгжим, орон зайн баримжаа, хөдөлгөөн, тэр ч байтугай хүмүүс хоорондын харилцаа гэх мэт өөр өөр салбарт онц гойд байж болно.

A gifted child

Child has a high level of mental ability or isextraordinarily good in a specific area of knowledge. Most countries consider a child to be gifted if his IQ score stands at 130 or beyond that. However, a gifted child could be great in different areas, such as verbal, mathematical, visual, art, musical, spatial, kinesthetic or even interpersonal communication.

Д

22. Дасан зохицох чадвар

Нийгмийн тогтсон хэм хэмжээ, тухайн нөхцөл байдалд нийцүүлэн үйлдэл, үйл ажиллагаа болон хувийн хариуцлагатай байх чадвар. Үүнд: харилцааны чадвар, өөртөө үйлчлэх, ахуй амьдралаа зохицуулах, олон нийтийн үйлчилгээний хэрэглээ, өөрийгөө хянаж удирдах, эрүүл мэнд, аюулгүй байдал, чөлөөт цаг, суралцахуйн чадварууд, ажил эрхлэлт орно.

Adaptive skills

Ability to act in accordance with social norms, circumstances, and personal responsibilities. These include: communication skills, self-care, self-control, use of community services, health and safety, leisure, academic functioning and work.

23. Дауны синдром

Бие махбодийн өсөлтийн саатал, нүүрний төрхийн онцлог шинж, бага ба дунд зэргийн хөгжлийн болон оюуны бэрхшээлийг дагуулсан генетикийн эмгэг. Энэ нь 21-р хромосомын бүрэн буюу хэсэгчилсэн нэмэлт хромосом байгаатай холбоотой юм.

Down syndrome

A genetic disorder associated with physical growth delays, characteristic facial features and mild to moderate developmental and intellectual disability. It is caused by the presence of full or partial extra copy of chromosome 21.

24. Дискриминац (Алагчилал)

Аливаа хүнийг арьс өнгө, хэл соёл, угсаа гарал, үзэл бодол, хөгжлийн онцлог, оюун ухаан, танин мэдэхүйн болон бие эрхтний ялгаатай байдал, тусгай хэрэгцээг үл хүндэтгэх, үл хүлээн зөвшөөрөх, ялгаварлан гадуурхах үзэл юм.

Discrimination

It is an act of disrespecting, rejecting, and discriminating people due to the race, language, culture, ethnicity, point of views, developmental characteristics, mental, cognitive, and physical differences.

25. Дохионы хэл

Хэл шинжлэлийн бүтэц, бүрэлдэхүүний хэв шинж бүрэлдсэн, хараанд суурилсан сонсголгүй хүмүүсийн "төрөлх хэл" юм.

Sign language

It is the "native language" of the deaf people, based on the structure and composition of linguistics.

26. Дохионы хэлний хэлмэрч

Дохионы хэл мэддэггүй сонсголтой иргэн ба сонсголгүй хүн хоорондын харилцааг хөрвүүлэн дамжуулдаг мэргэжилтэн.

Sign language interpreter

An expert in translating between a deaf person and a hearing person who does not know sign language.

27. Дуу чимээний хэмнэл (Герц)

Энэ нь сонсох чадварын түвшинг хэмжих нэгж. Дуу чимээний хэмнэлийг герц "Hz" гэнэ. Heinrich Rudolf Hertz-ийн нэрээр нэрлэгдсэн. Дуу чимээний түвшин, давтамжийг системтэйгээр өөрчлөн, сонсож чадах хамгийн нам авиаг тогтооно.

Frequency of sound (Hertz, Hz)

It is a unit for measuring hearing. The frequency of the sound is called the hertz "Hz". Named after Heinrich Rudolf Hertz. By systematically changing the noise level and frequency the lowest sound a person can hear is determined.

28. Дуу чимээний хүч (Децибел)

Сонсох чадварын түвшинг хэмжих нэгж, дуу чимээний хүчийг децибел "дБ" гэнэ. Хүний сонсож чадах хамгийн сул дуу авиаг тогтооно.

Sound pressure (Decibel, dB)

It is a unit of measurement of hearing and the rhythm of sound is called the hertz "Hz" and is named after Heinrich Rudolf Hertz. Determines the lowest sound by systematically change the frequency and noise level. The unit of measuring the level of hearing and sound pressure wave is the decibel "dB". It determines the lowest sound a person can hear.

29. Дэмжлэгийн 3 шатлалт загвар

Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг албан ёсоор хэрэгжүүлэхээс өмнө хийгдэх тухайн хүүхдийг дэмжих сургалтын үйл ажиллагааны тогтолцоо.

Three-tiered support system

A system to support learning activities of the child that take place before the formal implementation of an individual education plan.

30. Дэмжлэгийн баг

Дэмжлэгийн баг нь хүүхдийг сургуулийн орчинд дасан зохицоход туслах, тэдний хөгжлийн онцлог, давуу тал, сурч боловсрох, хөгжих хэрэгцээний судалгаа

хийх, багш эцэг, эх асран хамгаалагчдад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн дэмжлэг үзүүлэх, холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах чиг үүрэгтэй.

Support team

The support team is responsible for assisting children in adapting to the school environment, studying developmental characteristics, strengths, learning and developmental needs, providing methodological support to teachers and parents to work with children with disabilities, and cooperating with relevant professional organizations.

З

31. Зан төрх, танин мэдэхүйн бэрхшээл

“Developmental Disorder, Developmental Disability” гэдэг үгийг Монгол хэлэнд махчилж орчуулбал “хөгжлийн эмгэг, хөгжлийн бэрхшээл” гэж орчуулагдах боловч, ингэж орчуулбал хэт ерөнхий бөгөөд тухайн агуулгаас өөрөөр ойлгогдох талтай. Англи хэлэнд “Developmental Disability, Developmental Disorder” гэсэн 2 янзаар нэрлэж, нийгмийн халамжийн салбарт “Developmental Disability”, анагаах ухааны салбарт “Developmental Disorder” гэсэн байдлаар ялгаж ашигладаг. Японд “Хаттацү шёогай” буюу зан төрх, танин мэдэхүйн бэрхшээлийг “Аутизмын хүрээний эмгэг, Аспергерийн эмгэг болон бусад хөгжлийн ерөнхий эмгэг, суралцахуйн бэрхшээл, анхаарлын дутмагшил, хэт хөдөлгөөнтөх эмгэг болон түүнд хамаарагдах тархины

хөгжлийн эмгэг бөгөөд шинж тэмдгүүд нь бага насанд илэрдэг бэрхшээл” гэж тодорхойлсон байдаг. Өөрөөр хэлбэл “*зан төрх, танин мэдэхүйн бэрхшээл*”-д аутизмын хүрээний эмгэг, суралцахуйн бэрхшээл, анхаарлын думтагшил/хэт хөдөлгөөнтөх эмгэг гэсэн 3 бэрхшээлийг хамруулан ойлгоно.

Developmental disorder, disability

The word “developmental disorder, developmental disability” can be translated into Mongolian as “developmental (disease) disorder, disability”, but it is too general and may be understood differently from the context. In English, it is also referred to as Developmental Disability and Developmental Disorder, and is used in the social welfare sector as Developmental Disability and in medicine as Developmental Disorder. Therefore, it is necessary to translate the term into Mongolian and spread the proper concept to the society. At the international level, too, there are cases where different meanings are used depending on the country and the field used, and globally, there is not yet a common definition to all different areas. Therefore, the developers of this recommendation have initiated the concept of “Developmental Disorder, Developmental Disability” in the education sector to use as “Behavioral and Cognitive disabilities”.

In Japan Behavioral and Cognitive Disorders defined as “Autism Spectrum Disorders, Asperger’s and Other General Developmental Disorders, Learning Disabilities, Attention Deficit / Hyperactivity Disorders and related Brain Developmental Disorders the symptoms of which occur from childhood age”. In other words, “*behavioral and cognitive disorder*” includes three disorders such

as autism spectrum disorder, learning disabilities, and attention deficit hyperactivity disorder.

32. Зан үйлийн интервенцийн төлөвлөгөө

Сурагчийн зохисгүй зан үйлийг хөндлөнгийн оролцоотойгоор өөрчлөхөд чиглэсэн төлөвлөгөө; хөндлөнгийн оролцоо бүр нь хэмжиж болохуйц, тодорхой заасан зорилгот зан үйлийг тусгайлан авч үздэг.

Behavior Intervention Plan

A plan that targets a student's undesirable behaviors with interventions that are linked to the functions of the behavior; each intervention specifically addresses a measurable, clearly-stated targeted behavior.

33. Зөвлөгөө өгөх

Зан үйл, ажил хөдөлмөр, гэрлэлт, сургууль, нөхөн сэргээх эмчилгээ, сэтгэл хөдлөлөөс үүдэлтэй хувийн асуудлуудыг шийдвэрлэхэд мэргэжлийн туслалцаа үзүүлэх үйл ажиллагаа. Мэргэжилтэн нь идэвхтэй сонсох, ярилцах, үйлчлүүлэгчид зөвлөгөө өгөх, тодруулах, чиглүүлэх, дэмжлэг үзүүлэх аргуудыг ашигладаг.

Counselling

Professional help in handling and processes private problems, such as behavior-related, job-related, marriage, school, rehabilitative, life-stage, and emotionally rooted problems. The specialist employs methods of proactive listening, advising the client, talk therapy, clarifying, guiding and supporting the client.

И

34. Инчеоны тунхаглал

“2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөр”- ийн 4 дэх Тэгш хамруулах боловсролын зорилгын үзэл санаа, мөн боловсролын чанарын талаарх ойлголтыг гүнзгийрүүлэх, хэрэгжилтийг үр дүнтэй болгоход чиглэсэн багц асуултуудад хариулт өгөх хэлбэрээр боловсруулагдсан баримт бичиг. 2015 оны 2-р сард БНСУ-ын Инчеон хотноо зохион байгуулагдсан Боловсролын дэлхийн чуулга уулзалтаар “Тэгш хамран сургах, тэгш боломж бүхий чанартай боловсрол, бүх нийтийн насан туршийн боловсролоор хангах” зорилтыг дэвшүүлсэн.

Incheon Declaration

The Sustainable Development Program -2030 is a document designed to address the concept of Inclusive Education Goal, (the 4th goal) as well as a set of questions aimed at deepening the understanding of the quality of education and making its implementation effective.

In February 2015, the World Education Forum in Incheon, South Korea, set the goal of “providing inclusive education, quality education with equal opportunities, and lifelong learning for all”.

35. Илрүүлэг, илрүүлгийн үнэлгээ

Илрүүлгийн үнэлгээ нь эрсдэлтэй сурагчдыг тодорхойлоход багш нарт тусалдаг үнэлгээний эхний үе юм. Энэ нь ахиц дэвшил гаргахын тулд нэмэлт эсвэл өөр хэлбэрийн зааварчилгаа эсвэл нэмэлт оношилгоо шаардлагатай эсэхийг тодорхойлох эхний алхам юм.

Screening assessment

Screening assessment is the first step in assessment that helps teachers identify at-risk students. This is the first step in determining whether additional or other forms of instruction or additional diagnosis are needed to make further provision.

M

36. Маргиналчлал

Маргиналчлал гэдэг нь хүмүүсийг нийгмээс гадуурхах, үзэл суртал, ялгаатай байдлаасаа болж бусдад үл хүндэтгүүлэх явдал юм.

Marginalization

Marginalization is the exclusion of people from society, disrespecting due to their ideologies and differences from rest of people.

N

37. Нийгмийн загвар

Олон улсын үйл ажиллагааны ангиллын (ICF, 2001) дагуу боловсролын салбарт хүний "согог"-ийг онцлох бус, эрүүл мэнд, хувийн болоод нийгмийн хүчин зүйл, нийгмийн оролцооноос хамаарч хүний "үйл ажиллагааг" үнэлж хүртээмжтэй орчин бүрдүүлж суралцуулахад чиглэсэн загвар.

Social model

A model focusing not on “impairment” but on creating an inclusive learning environment that values human “function” based on health, personal and social factors, and social participation in education in accordance with the International Classification of Functioning (ICF, 2001).

38. Нийгэмшихүйн чадвар

Бусадтай харилцах, үүрэг хариуцлагаа ухамсарлан ойлгож биелүүлэх, өөрийн бурууг хүлээн зөвшөөрөх, дүрэм журмыг сахих, өөрийн биеэ хамгаалах гэх мэт чадваруудыг багтаадаг.

Social skill

It includes the ability to communicate with others, to understand one’s responsibilities, to admit own mistakes, to follow the rules, and to protect oneself.

39. Нормализаци

Нормал буюу хэвийн байдалд орно гэдэг бол тухайн хүнийг чадвар алдалтгүй хүний адил хэмжээнд ойртуулж, амьдралынх нь мөн чанарт (ажил, сургууль, гэр орон г.м.) үйлчлэх тэрхүү харилцаанд эргээд орох нөхцөл гэж ойлгоно.

Normalization

Normalization or coming back to normal condition refers to the process by which a person becomes as close as a non-disabled person and a relationship that serves the nature of his or her life (work, school, home, etc.).

40. Нэгтгэх, хослуулах

Хөгжлийн онцлогтой, чадварын өөрчлөлттэй хүүхдүүдийг шинж тэмдгийн ангиллаар нь ЕБС- ийн орчиндоо буюу дэргэдээ авах боловсролын хандлага.

Intergration

Educational approach to integrate children with disabilities in the mainstream school environment.

41. Нугасны эвэрхий

Хүүхдийн багана нурууны нугалам яс, нугасны хэвийн бус хөгжлийн улмаас үүсдэг төв мэдрэлийн тогтолцооны эмгэг.

Spina bifida

Congenital disorder of children's central nervous system caused by abnormal development of the vertebrae and spinal cord.

42. Нөөц өрөө

Нөөц өрөө гэдэг нь тусгай хэрэгцээтэй сурагчид хичээлийг нөхөн авах, гэрийн даалгавар болон холбогдох даалгаврыг шууд болон тусгай арга зүйгээр ганцаарчлан эсвэл бүлгээр гүйцэтгэх зориулалтын тусдаа анги юм.

Resource room

A resource room is a separate, remedial classroom in a school where students with special needs, such as specific learning disabilities, are given direct, specialized instruction and academic remediation and assistance with homework and related assignments as individuals or in groups.



1. 43 Олон соёлын боловсрол

Олон соёлын боловсрол гэдэг нь соёлын ялгаатай хүмүүсийн түүх, хэл, үнэт зүйл, итгэл үнэмшилд эн тэнцүү хүндэтгэлтэй хандсан боловсролын үйлчилгээ үзүүлэхийг хэлнэ.

Танхимын сургалтын үед багш нар тухайн ангийн сурагчдын соёлын олон талт байдлыг харгалзан хичээлийн агуулга, арга зүйг өөрчилж, олон хувилбартай болгож болно.

Multicultural education

Multicultural education refers to any form of education or teaching that incorporates the histories, language, values, beliefs, and perspectives of people from different cultural backgrounds. At the classroom level, for example, teachers may modify lessons to reflect the cultural diversity of the students in a particular class.

44. Оюун ухааны бэрхшээл

Хувь хүн дасан зохицох болон оюун ухааны чадвараа нийгмийн оролцоо болон өдөр тутмын практикт хэрэглэх үед тэдгээрт илэрхий хязгаарлалт үүсэхийг хэлнэ. Оюун ухааны бэрхшээлтэй хүний онцлог нь сурч хөдөлмөрлөх, юмыг ухааран ойлгоход бусдаас илүү их бэрхшээлтэй учирч, илүү хөдөлмөрлөх, бодож эргэцүүлэх шаардлага тулгардагт оршино. Эдгээр нь 18 наснаас өмнө илэрдэг.

Intellectual Disability

This disorder is characterized by below average cognitive functioning in two or more adaptive behaviors with onset before age 18. The characteristic of a person with intellectual disabilities is that he or she needed more efforts and has more difficulty in learning, working, and thinking than others.

45. Оюун ухааны сорил

Оюун ухааны сорил гэдэг нь сэтгэхүйн олон үйлдлийг үнэлэх аргачлал бөгөөд янз бүрийн даалгавруудыг гүйцэтгүүлэх замаар суралцагчийн тухайн үеийн оюун ухааны үйл ажиллагааг үнэлэх арга юм. Суралцагчийн оюуны чадавхыг (IQ) ихэвчлэн стандартын дагуу шаардлага хангасан буюу “стандартчиллагдсан” тестээр хэмждэг

Intelligence test

Intelligence test is an assessment tool of a student’s current intellectual functioning through a performance of various tasks designed to assess different types of reasoning. A student’s intelligence quotient (IQ) is typically measured by standardized test.

46. Оюун ухааны коэффициент

IQ буюу оюун ухааны коэффициент нь мэдээллийг боловсруулж, асуудлыг шийдвэрлэх чадварын хэмжүүр юм. Энэ нь үндсэндээ ижил насны бүлгийн бусад хүмүүстэй харьцуулахад тодорхой асуултыг хэр сайн гүйцэтгэснийг харуулна. IQ буюу оюуны коэффициентыг хуанлийн нас болон сорилын гүйцэтгэлийн оюуны насыг харьцуулан 100 -гаар үржүүлэн тооцоолж гаргадаг.

Intelligence quotient

IQ, or intelligence quotient, is a measure of an ability to reason and solve problems. It essentially reflects how well you did on a specific test as compared to other people of your age group. IQ or intelligence quotient is calculated by dividing the chronological age by the mental age accordingly to test performance and multiplying by 100.

47. Оюуны нас

Тухайн хүүхдийн сэтгэхүйн чадварыг, ижил насны хүүхдүүдийн сэтгэхүйн чадварын дундажтай харьцуулан гаргасан үзүүлэлтийг хэлнэ.

Mental age

It's an indicator of a child's mental ability, compared to the average mental ability of children at the same age.

48. Оюуны хөгжлийн эмгэгийн оношилгоо, статистикийн гарын авлага-V

Сэтгэцийн эмгэгийн оношилгоо, статистикийн гарын авлага 5 удаа шинэчлэн боловсруулагдсан сэтгэцийн эмгэгийг тодорхойлж, шинж тэмдгүүдийг тайлбарласан олон зуун мэргэжилтэн, эрдэмтдийн бүтээл юм.

The Diagnostic and Statistical Manual of Mental Disorders (DSM-V)

The Diagnosis and Statistics of Mental disorders has been revised five times and is the work of hundreds of experts and scientists who describe mental disorders and explain its symptoms.



49 Өвчин, согог

Бие эрхтний үйл ажиллагааны хүрээнд авч үзэх бөгөөд, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхэд хэрэглэгдэнэ.

Disease, impairment

It is considered in the context of physical activity and is used to provide health care service.

50. Өвчний олон улсын ангилал

ДЭМБ-аас боловсруулсан эрүүл мэнд, бие эрхтний өөрчлөлт, өвчлөлийн талаарх ангилал, тайлбарыг агуулсан гарын авлага.

Өвчний олон улсын ангилал нь тархвар судлал, эрүүл мэндийн менежмент, эмнэлзүйн зорилгоор дэлхий даяар хэрэглэгддэг оношлогооны хэрэгсэл юм. Үүнийг НҮБ-ын эрүүл мэндийн асуудлыг удирдан чиглүүлж, зохицуулах эрх бүхий байгууллага болох Дэлхийн эрүүл мэндийн байгууллага хариуцдаг.

International Classification of Diseases (ICD)

A handbook on health, physical organ changes, and disease classification and explanations developed by the World Health Organization.

The International Classification of Diseases is a globally used diagnostic tool for epidemiology, health management and clinical purposes. The ICD is maintained by the World Health Organization, which is the directing and coordinating authority for health within the United Nations System.

51. Өвчин согог, чадварын өөрчлөлт, бэрхшээлийн олон улсын ангилал (ДЭМБ, 1998)

“Impairment” буюу “өвчин, согог” гэдэгүгийг биеэрхтний хүрээнд авч үзэж эрүүл мэндийн салбарт хэрэглэхийг заасан, харин “Disability” буюу “чадварын өөрчлөлт/ алдалт” гэх ухагдахууныг хүүхдийн суралцахуйн, танин мэдэхүйн хүрээнд авч үзэж боловсролын салбарт хэрэглэхийг заажээ. “Handicap” буюу “саад, бэрхшээл” гэх үгийн утгыг хувь хүн болон нийгмээс үүдэлтэй тул нийгмийн салбарт хэрэглэнэ гэж зөвлөжээ.

International Classification of Impairment Disability and Handicap (WHO, 1998)

The word “impairment” considered for use in the health sector within the body system, while the term “disability” is considered in the context of children’s learning and cognition and is intended to be used in the field of education, the word “handicap” to be used in the social sphere because it is derived from the individual and society.

52. Өөрчлөлт

Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд хүүхдийн онцлог хэрэгцээнд тохируулан агуулга, арга зүй, үнэлгээнд өөрчлөлт “тохируулга” оруулах

Modification

Make an “adjustments” to the content, methodology, and assessment to meet the specific needs of the child in order to implement the curriculum and program

53. Өөрийгөө гэмтээх үйлдэл

Өөрийгөө гэмтээх гэдэг нь маш хэцүү мэдрэмж, гашуун дурсамж, хүнд хэцүү нөхцөл байдал, бэрхшээлийг даван туулахын тулд өөрийгөө гэмтээх явдал юм.

Self-Injury

Self-harm is when you hurt yourself as a way of coping with very difficult feelings, painful memories or overwhelming situations and experiences.

54. Өөртөө үйлчлэх чадвар:

Идэх, уух, алхах, гишгэх, ариун цэврийн өрөө орох, хувцас солих, хооллох бэлтгэл болоод цэвэрлэгээ, эмх цэгц, автобус болон тээврийн хэрэгсэлд суух, эмийг зааврын дагуу уух, утас хэрэглэх гэх мэт үйлийг багтаан ойлгоно.

Self care skills:

These include eating, walking, using the bathroom, changing clothes, preparing meals, cleaning, tidying up, getting on buses and vehicles, taking medication as directed, and using telephones.



55. Саад бэрхшээлгүй орчин

Биеийн болон оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст саад тотгор учруулахгүй, аюулгүй, саадгүй хөдөлгөөн хийх боломжтой баригдсан орон зай.

Barrier-free environment

A built space that is free of obstacles to individuals with

physical and cognitive disabilities and permits safe, uninhibited movements.

56. Саламанкагийн тунхаглал

Тэгш хамрах үзэл санаа нь дэлхийн бүх орнуудын боловсролын бодлогын үндсэн зорилго болохыг тодорхойлсон, уриалга бүхий баримт бичиг.

Salamanca declaration

A document promoting inclusion and defining it as a key goal of education policy in all countries of the world.

57. Салбар дундын мэргэжилтний баг

Салбар дундын мэргэжилтний баг нь хүүхдийг тусгай боловсролд хамрагдахыг үнэлэх, тухайн хүүхдэд зориулсан хувь хүний боловсролын хөтөлбөр (IEP) бий болгох гэх мэт нийтлэг зорилгоо биелүүлэхээр цугласан олон салбарын хүмүүс юм.

The Multidisciplinary Team

A multidisciplinary team is a group of individuals from multiple disciplines who meet to pursue a common goal, such as evaluating a student for placement in special education or creating an individualized education program (IEP) for a student.

58. Сонголын бэрхшээл

Сонгол бууралтын улмаас дуу чимээ хүлээн авч чадахгүй буюу "сонсох түвшин сул" байхыг хэлнэ. Бэрхшээл нь сонголын эрхтний аль хэсэгт үүссэн, сонгол алдагдлын хэмжээ, хүлээн авч буй дууны давтамжийн тоо, сонгол алдагдаж эхэлсэн хугацаа зэргээс хамаарч янз бүр байна.

Hearing impairment

Hearing impairment is the inability to receive sound or "poor hearing". Hearing loss is a problem depending on the extent of hearing loss, the level of frequencies of the sound received, and the time of onset of hearing loss.

59. Сонсголгүй (дүлий)

Хэл яриагаар илэрхийлэгдэж буй мэдээллийг сонсголын эрхтнээрээ дамжуулан хүлээн авах боломжгүй болсон сонсголын бүрэн чадвар алдалт

Deaf

Complete hearing loss in the ability to receive speech information through the auditory system

60. Сонсголын бичлэг

Сонсголын түвшинг тодорхойлохын тулд аудиометрийн аргаар оношилгоо хийж буй үйл ажиллагаа.

Hearing test

Audiometric diagnostic procedure to determine hearing level.

61. Суралцахуйн бэрхшээл

Оюун ухааны хөгжлийн хэвийн чадвар ба суралцах үйл ажиллагаа хоорондын ялгаатай байдал, мэдээллийг хүлээн авах, боловсруулах, хадгалах, илэрхийлэх 4 үе шат дахь танин мэдэхүйн үйл ажиллагаанаас хамааралтай суралцах явцад үүсэх бэрхшээл нь "суралцахуйн бэрхшээл" болно.

Learning Disability

Special education term used to define a disorder in one

or more of the basic psychological processes involved in understanding or using language spoken or written that may manifest itself in an imperfect ability to listen, think, speak, read, write, spell or do mathematical equations.

62. Суралцахуйн түгээмэл загвар

Суралцахуйн түгээмэл загвар нь суралцах үйл ажиллагааг тархины мэдрэлийн систем, эд, эс, тэдгээрийн хоорондын сүлжээ, холбоосын түвшинд гурван зарчмын дагуу явагддаг үйлдлийг тодорхойлдог. Суралцахуйн түгээмэл загварыг CAST (www.cast.org) байгууллага боловсруулсан юм. СТЗ нь бүх суралцагчдын хэрэгцээг идэвхтэй хангахын тулд суралцахуйн загварыг чиглүүлдэг. СТЗ-ын үзэл санаал бол суралцахад саад болж буй бэрхшээл нь суралцагчид биш харин хүрээлэн буй орчны загварт байгаа гэж үздэг.

Universal Design for Learning

Universal design for learning defines the process of learning according to three principles at the level of the nervous system, tissues, networks, and connections between them.

Universal Design for Learning (UDL) is a framework developed by CAST, an Understood founding partner. UDL guides the design of learning experiences to proactively meet the needs of all learners. When you use UDL, you assume that barriers to learning are in the design of the environment, not in the student.

63. Сэтгэлийн хөдөлгөөн, зан төрхийн эмгэг

Хэвийн нөхцөл байдалд зохисгүй зан үйл гаргаж, мэдрэмжээ сөрөг байдлаар илэрхийлдэг эмгэг. Үе

тэнгийнхэн болон багш нартайгаа сэтгэл ханамжтай эерэг харилцааг бий болгох, харилцааг хадгалах чадваргүй байдаг. Ихэнхдээ аз жаргалгүй эсвэл сэтгэлийн хямралтай байх нь түгээмэл.

Emotional Disturbance

An inability to build or maintain satisfactory interpersonal relationships with peers and teachers. Inappropriate types of behavior or feelings under normal circumstances. A general pervasive mood of unhappiness or depression.

64. Сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ

Хүүхдийн талаар мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, үр дүнг тайлбарлах, хэрхэн ажиллах, дэмжих талаар зөвлөгөө өгөх үйлчилгээ

Psychological counseling service

Procedures on collecting and analyzing information about children through psychological and educational tests, analyzing and interpreting the results, and counselling on how to cope and support the child

65. Сэргээн засах

Хоригдох, донтох, эсвэл өвчин туссаны дараа сургалт, эмчилгээгээр дамжуулан хэн нэгнийг эрүүлжүүлж, хэвийн амьдралд буцаан оруулах үйл ажиллагаа.

Rehabilitation

The action of restoring someone to health or normal life through training and therapy after imprisonment, addiction, or illness.

T

66. Танака Бине сорил

“Танака Бине-V оюун ухааны сорил”-ыг Японд 1947 -2003 оны хооронд 5 удаа шинэчилж боловсруулах судалгааны ажлууд хийгдсэн. Энэхүү аргачлалыг Монгол хувилбарт нутагшуулах ажлыг Нагоя Их Сургууль, МУБИС-ийн багш нар Танака Бинегийн Боловсролын хүрээлэнгийн албан ёсны зөвшөөрөлтэйгээр боловсруулсан. Судалгааны ажлыг хийхдээ япон хэл дээрх сорилын мөн чанарыг хадгалан Монгол орны нийгэм, ахуй, соёл, хэлний онцлогт нийцүүлэн өөрчилж, найдварт болон тохироц чанарыг статистик боловсруулалтаар тооцоолон гаргасан. Монгол Танака Бине оюун ухааны сорилын аргачлал нь оноожуулах, онолын, сорил авах гэсэн 3 гарын авлага, мөн багц хэрэглэгдэхүүнтэй бөгөөд 2-12 насны хүүхдийн оюуны нас, оюуны итгэлцүүрийг тодорхойлох боломжтой сорил юм.

Tanake Bine Test

The Tanaka Bine-V Intelligence Test was revised in Japan for the fifth time between 1947 and 2003. The introduction of this methodology in the Mongolian version was developed with the official permission of the Tanaka Bine research Institute with professors from faculty of Nagoya University and the Mongolian National University of Education. The research was conducted taking into account of Mongolian social, economic, cultural and linguistic characteristics, while maintaining the nature of the test in Japanese, the reliability and

validity were determined by statistical processing, and average standards were calculated. "Mongol Tanaka Bine" intelligence test is a test that can determine the intellectual age and intellectual coefficients of children aged 2-12 years with a set of manuals: test manuals, theoretical manuals and a set of tools.

67. Тархины саажилт

Тархины тодорхой хэсгүүд гэмтсэний улмаас тархи нь хөдөлгөөнөө удирдах чадваргүй болж, хүний биеийн хөдөлгөөн хяналтгүй болох эмгэг юм.

Cerebral parlsy

Disorder in which certain parts of the brain are damaged and the brain becomes unable to control its muscles, making it difficult to control one's movements and behavior.

68. Тусгай боловсрол

Тусгайлсан боловсролын зааварчилгаатай, эцэг эх, асран хамгаалагчаас нэмэлт зардлыг үл шаардсан, хүүхдийн тусгай хэрэгцээнд нийцүүлсэн, анги танхим, гэр орон, эмнэлэг, олон нийтийн газар зэрэг бүхий л орчинд тохируулсан өөр өөрийн гэсэн чиглэл бүхий хөтөлбөр, арга зүй юм.

Special education

It is a program and methodology with specific educational guidelines, but without additional costs for parents and guardians, adapted to the special needs of children, and to all environments, such as classrooms, homes, hospitals, and public places.

69. Тусгай хэрэгцээт боловсрол

Тусгай хэрэгцээт боловсрол нь суралцагчийн бие махбод, зан үйл, оюун ухаан, сэтгэл хөдлөлийн болон нийгмийн чадвар зэргээс шалтгаалан боловсролын үйлчилгээнд хамрагдан сургалтын зорилгыг биелүүлэхийн тулд хувь хүнд үзүүлэх нэмэлт дэмжлэг, тохируулга, тусгай хэрэглэгдэхүүн, арга зүй юм.

Special needs education

Education designed to facilitate the learning of individuals who, for a wide variety of reasons, require additional support and adaptive pedagogical methods in order to participate and meet learning objectives in an educational programme.

70. Тусгаарлах

Чадварын өөрчлөлттэй, тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийг шинж тэмдгээр нь ангилж тусгаарлан тусгай сургуульд тусгай хөтөлбөрөөр, тусгай арга зүйгээр тусгайлан бэлтгэгдсэн багш нар хичээл сургалтыг явуулах боловсролын хандлага.

Segregation

Educational approach to carry out the learning by specialized teachers with special programs and special methodologies in special schools by classifying children with disabilities.

71. Тусгай сургууль

Тусгай сургууль гэдэг нь бие бялдар, оюун ухааны бэрхшээл зэрэг шалтгаанаар боловсролын үйлчилгээг тусгайлан үзүүлдэг сургууль юм. Тусгай сургуулиудыг тусгайлан зохион байгуулж, тусгай боловсон хүчин, нөөцөөр хангана.

Special school

A special school is a school that specifically provides educational services for physical and mental disabilities. Special schools are organized and provided with special personnel and resources.

72. Тусгай хэрэгцээт боловсролын үйлчилгээ

Тусгай хэрэгцээт хүүхдэд зайлшгүй шаардлагатай, наад захын хэрэгцээг хангахын тулд байршил, давтамж, хүний нөөц, үргэлжлэх цаг хугацаа зэргээс үл хамаарч хүртээмжтэй байдлыг бүрдүүлж буй үйлчилгээг хэлнэ.

Special education service

It is a service that is accessible for children with special needs, regardless of location, frequency, human resources or duration, to meet their necessary basic needs.

73. Тусгай хэрэгцээт хүүхдийн үнэлгээ

Тухайн хүүхдэд тусгай боловсролын үйлчилгээ шаардлагатай эсэхийг дараах үе шаттай зохион байгуулж, үнэлгээ хийнэ. Үүнд: Илрүүлэх, тодруулах, оношлох, тодорхойлох, дэмжлэг үзүүлэх цогц үйлчилгээ (тогтолцоо) хэрэгжинэ.

Special education needs assessment

The following steps will be taken to assess whether the child needs special education services. These include: A comprehensive service (system) for screening, identification, diagnosis, determination and support.

74. Тусгай хэрэгцээт боловсролын мэргэжилтэн

Боловсролын тухай хууль, стандартад нийцсэн боловсролын үйлчилгээ үзүүлдэг дээд боловсролын байгууллагад суралцаж бэлтгэгдсэн, тусгай хэрэгцээт боловсролын үйлчилгээ шаардлагатай хүүхэдтэй ажиллах мэргэжилтэнд тавигдах мэргэжил, ёс зүйн шаардлагыг хангасан мэргэжилтэнг хэлнэ.

Special education specialist

A specialist who is trained in a higher education institution that provides educational services in accordance with the Law on Education and standards and meets the professional and ethical requirements for working with children with special educational needs.

75. Тусгай боловсролын багшийн стандарт

Боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхэдтэй ажиллах багш мэргэжилтэнд тавигдах 12 бүлэг бүхий стандарт үзүүлэлтүүдийг (мэргэжлийн болон ёс зүйн шаардлага) багтаасан баримт бичиг юм.

Special education teachers' standard

It is a document containing 12 chapters of standard indicators (professional and ethical requirements) for teachers and professionals working with children with special educational needs.

76. Туслах (дэмжих) хэрэгсэл

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан туслах, дасан зохицох, нөхөн сэргээх зориулалттай хэрэгсэл нь өмнө хийж чадахгүй байсан эсвэл биелүүлэхэд ихээхэн бэрхшээлтэй байсан үйл ажиллагаа, үйлдлүүдийг дэвшилтэт технологийн тусламжтай гүйцэтгэх боломжийг олгодог.

Assistive technology

Assistive, adaptive and rehabilitative devices for people with disabilities which enable people to perform tasks that they were formerly unable to accomplish, or had great difficulty accomplishing, by enhancing or modifying interactions with the technology needed to accomplish such tasks.

77. Түгээмэл загвар

“Түгээмэл загвар” гэж ямарваа нэгэн нэмэлт тохиргоо, тусгай загвар шаардагдахгүйгээр бүх хүн ашиглахад хамгийн дээд зэргээр тохиромжтой байж болох бүтээгдэхүүн, байрлал, програм болон үйлчилгээний хэв маягийг хэлнэ. Түгээмэл загварт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс шаардлагатай тохиолдолд хэрэглэх туслах хэрэгслүүдийг орхигдуулахгүй байх (НҮБ, ХБХЭК).

“Түгээмэл загвар” гэдэг нь тохируулсан тусгайлан загварчилсан гэхээсээ илүү бүх хүмүүст ашиглах боломжтой бүтээгдэхүүн, орчин, программ, үйлчилгээний загварыг хамгийн ихээр ашиглахыг хэлнэ. “Түгээмэл загвар” нь шаардлагатай бол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тодорхой бүлэгт зориулсан туслах төхөөрөмжийг хамааруулна.

Universal design

Universal design means the design of products, environments, programs and services to be usable by all people, to the greatest extent possible, without the need for adaptation or specialized design. “Universal design” shall not exclude assistive devices for particular groups of persons with disabilities where this is needed. (Convention on the Rights of Persons with Disabilities)

“Universal design” means the maximum use of a product, environment, software program, or service model that is accessible to all people, rather than a specially designed one.

78. Тохиргоот орчин

ХБХ бусдын нэгэн адил үндсэн эрх, бүхий л хүний эрх чөлөөг эдлэх явдлыг хангах үүднээс тухайн орчинд зохицоогүй, эсхүл үндэслэлгүй саад тотгорыг арилгах, багасгахад чиглэгдсэн нэн хэрэгцээтэй тохируулга хийх болон өөрчилж засварлахыг хэлнэ. “Тохирох хэрэглэгдэхүүн” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн үндсэн эрх, эрх чөлөөг тэгш эдлэхэд зориулсан нэн хэрэгцээтэй тоног төхөөрөмж, материал, хэрэгсэл, программ хангамж, орчин нөхцөл, үйлчилгээг хэлнэ.

Reasonable accommodation

It means necessary and appropriate modification and adjustments not imposing a disproportionate or undue burden, where needed in a particular case, to ensure to persons with disabilities on an equal basis with others of all human rights and fundamental freedoms. “Reasonable accommodation” means essential equipment, materials, tools, software, facilities and services for the equal enjoyment of fundamental human rights and freedoms by persons with disabilities.

79. Төв мэдрэлийн систем

Мэдрэлийн тогтолцоо дотроос тархи болон нугасыг нийлүүлээд төв мэдрэлийн тогтолцоо гэнэ. Нугас нь биеийн бүхий л эд эрхтнүүдээс ирэх мэдээллийг тархинд дамжуулах, тархинаас ирэх дохиоллыг бие организмын бүхий л эд эрхтэнд дамжуулах үүрэгтэй.

Тархи нь захын мэдрэлийн тогтолцооноос ирэх мэдээлэл буюу өдөөгч үйлдлийг хүлээн авч тухайн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн шийдвэр гаргах гол чухал үүргийг гүйцэтгэдэг.

Central Nervous System

The complex of nerve tissues that controls the activities of the body. In vertebrates it comprises the brain and spinal cord. The spinal cord is responsible for transmitting information from all parts of the body to the brain, and signals from the brain to all parts of the body. The brain receives information or stimuli from the peripheral nervous system and plays a key role in making decisions according to needs.

80. Тэгш хамруулах боловсрол

Бүх суралцагчдын нийгэм, соёл, боловсролын үйл ажиллагаа дахь тэгш оролцоог хангах, боловсролын гаднах болон доторх бүх хэлбэрийн ялгаварлан гадуурхалтыг бууруулах замаар сурагч бүрийн ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн боловсролын үйлчилгээг хүргэх үйл явц (ЮНЕСКО, 2008). Тэгш хамруулах боловсрол нь хүүхэд нэг бүрийн боловсролын хэрэгцээнд нийцүүлэн боловсролын талаар баримтлах бодлого, үзэл хандлага, сургалтын орчин, багшийн сургалтын арга зүй, харилцааг өөрчлөн шинэчлэхэд чиглэгддэг үйл явц юм.

Inclusive education

The process of delivering educational services to the different needs of each student by ensuring equal participation in the social, cultural and educational activities of all students and reducing discrimination in all

forms of education, both outside and inside. (UNESCO, 2008) Inclusive education is the process of changing, renewing education policies, learning environments, teacher training methods and attitudes towards each child's educational needs.

81. Тэгш боломж

Тэгш байдал гэдэг нь бүгдэд ижил зүйлийг олгохыг хэлдэг бол тэгш боломж нь бид бүгд нэг газраас эхэлдэггүй, энэхүү тэнцвэргүй байдлыг засах ёстой гэдгийг хүлээн зөвшөөрөхийг хэлнэ. Энэ үйл явц үргэлжилсээр байгаа бөгөөд биднээс өрөөсгөл хандлага эсвэл системийн бүтцээс үүдэлтэй санаатай болон санамсаргүй саад бэрхшээлийг тодорхойлж, даван туулахыг шаардаж байна.

Equity

Whereas equality means providing the same to all, equity means recognizing that we do not all start from the same place and must acknowledge and make adjustments to imbalances. The process is ongoing, requiring us to identify and overcome intentional and unintentional barriers arising from bias or systemic structures.

Y

82 . Үйл ажиллагааны олон улсын ангилал

Энэхүү нэр томъёо нь "өвчин, согог", "чадвар алдалт", "саад, бэрхшээл" зэргийг "үйл ажиллагаа"-гаар орлон төлөөлүүлсэн үг хэллэг бөгөөд нийгмийн зэрэг хандлагаар илэрхийлэхийг зорьжээ.

International classification of functioning:

The term is used to replace terms such as “impairment”, “disability”, and “handicap” with the term “function” and is intended to convey a positive social attitude.

83. Үнэлгээ

Үнэлгээ гэдэг нь хүүхдийн сурах онцлог, давуу тал, хэрэгцээг тодорхойлох, тусгай боловсролын үйлчилгээнд хамрагдах эсэхийг тодорхойлоход чиглэгддэг. Тусгай боловсролын үнэлгээ нь шийдвэр гаргах зорилгоор сурагчийн талаарх мэдээллийг цуглуулах, үнэлэх үйл явц юм.

Assessment

Assessment is a process used to determine a child’s learning characteristics, strengths, and needs, and to decide whether they are eligible for special education services. Special education assessment is the process of gathering information about a student for decision-making purposes.

X

84 Хамтран суралцахуй

Нэг ангийн сурагчдыг бүлэгт хуваан, бүлгийн сурагч бүрийн амжилт нь хамтран суралцахуйгаас хамаарах байдлаар зохион байгуулах сургалтын үйл явц юм.

Cooperative Learning

It’s involves structuring classes around small groups that work together in such a way that each group member’s success is dependent on the group’s success.

85. Хамтран багшлахуй

Нэг ангид хоёр багш, ихэвчлэн тусгай боловсролын багш болон ангийн багш хамтран ажиллах нөхцөл байдлыг хэлнэ.

Co-operative teaching

It is a situation where two teachers work on a class together. It is often used in classrooms where a classroom teacher collaborates with a special educator.

86. Харааны бэрхшээл

Хүүхдийн боловсрол эзэмшихэд сөргөөр нөлөөлж буй харах үйл ажиллагааны чадвар алдалт. Тус ойлголтод хэсэгчлэн болон бүрэн харах чадваргүй хүүхдүүд аль аль нь хамаарна.

Visual impairment

That negatively affects children's educational performance. This concept includes both partially and completely blind children.

87. Хараагүй

Нийт харах орчны хичнээн хувь нь алдагдаж байгаагаас шалтгаалан тухайн хүний харааны бэрхшээлийн ангиллыг тодорхойлдог. Харах орчны 80 буюу түүнээс дээш хувь нь алдагдсан бол бүрэн хараагүй гэж үзнэ.

Blind

Depending on what percentage of the total visual field acuity is lost, a person's visual impairment is determined. If 80 percent or more it is considered the person is blind.

88. Хараагүйдэл

Хараагүйдэл гэдэг нь хүн юмыг огт харж чадахгүй байхыг хэлнэ. Бүрэн хараагүйдэл нь гэрлийг мэдэрдэг, мэдэрдэггүй гэж хоёр төрөл байна.

Blindness

Blindness means that a person cannot see at all. There are two types of complete blindness: those who feel light and those who do not.

89. Харааны чадал

Нүдэнд юмс тод харагдахгүй, бүрэлзэж харагдаж байгаагаар харааны чадлыг тодорхойлно.

Visual acuity

Visual acuity is determined by the fact that things are not clearly visible to the eye.

90. Харааны өнгө үл ялгах үйлдэл:

Харааны өнгө ялгах үйлдлийн алдагдлыг хэлнэ. Харааны хэт ачааллын үед нүдний оптик элементүүд хэт ачаалалтай болж өнгө ялгах чадвар буурах магадлал ихэсдэг. Харааны чадвар суларсан үед өнгө ялгах чадвар мөн тодорхой хэмжээгээр алдагдаж эхэлдэг.

Color blindness

During visual overload, the optical elements of the eye become overloaded and the ability to distinguish colors decreases. When vision is impaired, the ability to distinguish colors also begins to be lost to some extent.

91. Хавсарсан бэрхшээл

Нийтлэг тусгай боловсролын хөтөлбөрийн дагуу суралцах боломжгүй, нэг болон түүнээс дээш хэлбэрийн хөгжлийн бэрхшээлийн шинж тухайлбал оюуны бэрхшээл, харааны бэрхшээл хавсарсан тусгай боловсролын үйлчилгээ хэрэгцээтэй хүүхэд.

Multiple disability

A term used to define a combination of disabilities that causes special educational needs that require multiple special education services, i.e. program for student with mental retardation with blindness.

92. Хүүхдийн хөгжлийн үнэлгээ

Тухайн хүүхдийн эрхтэн системийн үйл ажиллагааны, хөгжлийн, боловсролын, эцэг эхийн, багшийн, холбогдох бусад мэдээллийг ашиглан хүчин төгөлдөр, найдвартай үнэлгээний хэрэглэгдэхүүнийг ашиглан мэргэжлийн мэргэшсэн хүний удирдлаган дор төрөлх хэл дээр хийгдэж буй "хүүхдийн хөгжлийн суурь түвшин"-г тодорхойлох цогц үйл явц.

Child development assessment

A comprehensive process of determining a child's "basic level of development" in his or her native language under the guidance of a professionals using valid and reliable assessment tools using functional, developmental, educational, parental, teacher, and other relevant information.

93. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц (НҮБ)

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай

конвенцыг 2006 оны арванхоёрдугаар сарын 13-ны өдөр НҮБ-аас баталсан, 2008 оны тавдугаар сарын 3-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүний эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлэх явдлыг хангах, хамгаалах, хөхиүлэн дэмжих, түүнчлэн тэдний нэр төр, нандин чанарыг хүндэтгэн дэмжихэд оршино конвенцын зорилго оршдог. Манай улс Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцод 2009 онд нэгдэн орсон бөгөөд уг конвенцын 24-р зүйлд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс боловсрол тэгш, хүртээмжтэй эзэмших эрхтэйг баталгаажуулсан байдаг.

Convention on the Rights of Persons with Disabilities (UN)

The Convention on the Rights of Persons with Disabilities was adopted on 13 December 2006 at the United Nations. The Convention entered into force on 3 May 2008. The purpose of this Convention is to ensure that all persons with disabilities enjoy all human rights and fundamental freedoms, ensuring, protecting and promoting the full enjoyment of liberty, as well as them respect and dignity. Mongolia acceded to the Convention on the Rights of Persons with Disabilities in 2009, and Article 24 of the Convention guarantees the right to equal access to education for persons with disabilities.

94. Хөдөлгөөн засалч

Үйл ажиллагааны чадвар алдалтыг үнэлэх, оношлох, сэргээн засах үйлчилгээ үзүүлдэг мэргэжилтэнг хэлдэг.

Physical therapist

A specialist who provides assessment, diagnosis, and rehabilitation services for person with physical disability.

95. Хөгжлийн бэрхшээлийн олон улсын ангилал

Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллагаас (WHO) хүний үйл ажиллагааг олон талаас нь судалж өөр өөр салбарын мэргэжлийн хүмүүст зориулан, салбар тус бүрийн хамрах хүрээ, чиглэл ойлголтыг тодорхой болгохын тулд гаргасан зөвлөмж.

International classification of impairment, disability and handicap – ICDH

Recommendations from the World Health Organization (WHO) to study human activities from many perspectives and to clarify the understanding of professionals in different fields.

96. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль

2016 онд УИХ-аар батлагдсан энэхүү хуулийн зорилт нь хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох тэгш эрх, түүнийг хангах, хэрэгжүүлэх, хамгаалах талаар төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, оролцоо, баримтлах зарчмыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Law on the Rights of Persons with Disabilities

The purpose of the Law on the Rights of Persons with Disabilities which passed in 2016 is to regulate the rights of persons with disabilities to participate in social relations, and to define the rights, duties, participation and principles of state organizations, citizens and legal entities in ensuring, implementing and protecting them.

97. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн комисс

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 37.2.1 дагуу 0-16 насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс тогтооно.

Commission on Health, Education and Social Welfare of Children with Disabilities

According to Article 37.2.1 of the Law on the Rights of Persons with Disabilities in Mongolia the Commission on Health, Education and Social Welfare of Children with Disabilities shall determine whether a child aged 0-16 has a disability.

98. Хэл засалч

Хүүхэд эх хэлээрээ харилцаанд орох үед яриаг хүлээн авах, ойлгож ухамсарлах, өөрийн яриа, санаа бодлоо бусдад зөв цэгцтэй ойлгуулахад гарч буй бэрхшээлийн төрлийг засан сайжруулж, сэргээн засах үйлчилгээ үзүүлдэг мэргэжилтэнг хэлдэг.

Speech therapist

An expert in correcting and rehabilitating the types of problems that arise when a child, when a child has language or speech disorder in receptive, expressive language or communication problems in his or her native language.

99. Хэрэглээний зан үйлийн шинжилгээ

Хэрэглээний зан үйлийн шинжилгээ (АВА) нь зан төлөвийг өөрчлөхийн тулд суралцахуйн онолын сэтгэлзүйн зарчмуудыг системтэй хэрэгжүүлэх практик

юм. Энэхүү туршилтын арга нь, аутизмын хүрээний эмгэгтэй (АХЭ) хүүхдийн харилццаг дэмжихэд өргөн хэрэглэгддэг.

Applied Behavior Analysis - ABA

Applied Behavior Analysis (ABA) is the practice of applying the psychological principles of learning theory in a systematic way to modify behavior. The practice is used most extensively in special education and the treatment of autism spectrum disorder (ASD).

100. Хуанлийн нас

Хүүхдийн эхээс мэндэлсэн өдрөөс (аргын тоолол) эхлэн тоолох нас.

Calendar age

The common use of a calendar age to mark the threshold of old age assumes equivalence with biological age, yet at the same time.

101. Хурууны үсэг

Гарын арван хурууны үйл хөдлөл, хөдөлгөөнөөр бичгийн хэлний бүх үсгийг дүрслэхийг хэлнэ. Монгол хурууны 35 үсэг байдаг.

Finger alphabet

The movement of the ten fingers of the hand describes all the letters of the written language. There are 35 Mongolian Finger Alphabet letters.

102. Хүртээмж

Хүн бүр хэрэглэж болох бүтээгдэхүүн болон үйлчилгээний тухай ойлголт. Хөгжлийн бэрхшээлтэй

хүмүүст туслах зорилгоор хүртээмжтэй байдлын тухай хууль байдаг. Иймд дизайнерууд бүх хэрэглэгчид ашиглах боломжтой олон хувилбартай, хүн бүхэнд нийцэхүйц бүтээгдэхүүний загварыг бий болгохыг хичээх хэрэгтэй.

Accessibility

The concept of whether a product or service can be used by everyone. Accessibility laws exist to aid people with disabilities, designers should try to accommodate all potential users in many contexts of use.

103. Хөгжлийн онцлог

Тусгай боловсролын харилцан уялдаа бүхий гурван үндсэн нэр томъёоны нэг бөгөөд, бусад нь согог, саад бэрхшээл. Хөгжлийн онцлог гэдэг нь бие эрхтний согогийн улмаас хүний зан төлөв, харилцах чадвар, өөртөө үйлчлэх чадвар. хөдөлгөөнт байдал, өдөр тутмын амьдралын чадвар зэрэгт үзүүлэх нөлөөлөл юм. *Dis-ability* нь хөгжлийн бэрхшээл биш бөгөөд чадварын хувьд харилцан адилгүй, өөр өөрийн ялгаатай замаар хөгжих боломжтой. *Иймд Disability гэх нэр томъёог "Хөгжлийн онцлог" хэмээн ойлгож утгачлан орчуулбал тохиромжтой.*

Disability

One of the three key interlocking terms in special education, the others being impairment and handicap. Disability is the effect the impairment has on an individual's behavior, ability to communicate. personal care. mobility etc. In fact in the abilities of daily living.

Dis-ability is not in-ability, it's a different ability in a different way of development. *Therefore, the term Disability should be translated as "Хөгжлийн онцлог".*

104. Хөдөлгөөний бэрхшээл

Олон улсад ихэвчлэн тархины саажилт, нугасны эвэрхий, тархины гэмтлийн улмаас үүсэх үйл хөдлөл, хөдөлгөөнөө удирдах, хянах чадварын өөрчлөлтийг багтаан авч үздэг. Дөрвөн мөч (дээд, доод мөч) болон их биеийн хөдөлгөөний үйл ажиллагааны өөрчлөлтийг хөдөлгөөний бэрхшээл гэнэ.

Physical disabilities

Internationally, it often includes changes in the ability to control the movements and activities caused by cerebral palsy, spinal cord injury, and brain injury. Changes in the movement of the four limbs (upper and lower limbs) and a change in the movement of the trunk is called physical disabilities.

105. Хөтөч нохой

Харааны бэрхшээлтэй хүнийг аюулгүй зорчиход замчин, газарчин нь болдог. Хөтөч нохой тусгай зориулалтын хүзүүвч зүүдэг. Тэр зүүлтийг зүүсэн тохиолдолд хөтөч хийж буйг илэрхийлдэг.

Guide dog

When a visually impaired person travels safely, the trained dog becomes a guide. A guide dog wears a special collar which shows that it is a guide dog.

106. Хязгаарлалт багатай орчин

Тусгай хэрэгцээтэй хүүхэд тусгай сургууль, тусгай анги, ердийн сургуулийн тусгай анги, ердийн ангид суралцах, сургуулийн орчноос бусад орчинд буюу хичээлээс гадуурх үйл ажиллагаанд оролцоход ч тухайн хүүхдийн тусгай хэрэгцээнд “нийцсэн” орчин бүрдэхийг хэлнэ.

Least Restrictive Environment (LRE)

When a child with special needs attends a special school or a special class, or a special class of a regular school, or a regular class, or participates in extracurricular activities outside the school environment, an environment is created that “meets” the child’s special needs.

107. Хэл яриа, харилцааны бэрхшээл

Хэл яриа, харилцааны бэрхшээл гэдэг нь хэл, яриаг ойлгох, хэрэглэх, бусадтай үр дүнтэй яриа өрнүүлэхэд нөлөөлдөг аливаа бэрхшээл юм. Саатал, эмгэг нь энгийн дуу авиаг солихоос эхлээд төрөлх хэлээ ойлгох, ашиглах чадваргүй болох хүртэл байж болно.

Language and communication disability

A communication disorder is any disorder that affects an individual’s ability to comprehend, detect, or apply language and speech to engage in discourse effectively with others. The delays and disorders can range from simple sound substitution to the inability to understand or use one’s native language..



108. Цагаан таяг:

Огт хараагүй хүмүүсийн бие даан алхаж явахад аюулгүй байдлыг хангах, нэг хоёр алхмын өмнөх замыг мэдрэх, мэдээлэл олж авахад зориулагдсан туслах хэрэгсэл.

White cane:

An assistive tool for blind people to walk safely, to feel the path one or two steps ahead, and to get information.

Ч

109. Чадварын өөрчлөлт

Танин мэдэхүй, суралцах үйл ажиллагааны хүрээнд авч үзэх бөгөөд боловсролын үйлчилгээ, хүүхэд төвтэй сургалтын үйлчилгээ үзүүлэхэд хэрэглэгдэнэ.

Change of abilities

It is used in the context of cognitive and learning activities and is used to provide educational services and child-centered learning services.

Ш

110 Шилжилтийн /хувь хүний/ хөтөлбөр

Тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийг сургуулийн өмнөх боловсроос ерөнхий боловсролын сургуулийн бага ангид, бага ангиас дунд ангид, дунд ангиас ахлах ангид дэвшин суралцахад зориулсан сургалтын хөтөлбөр юм. Мөн ахлах ангиас сургууль төгссөний дараах амьдралд бэлтгэх, ажил мэргэжлийн чиг баримжаа олгоход чиглэгдсэн "сургалтын хөтөлбөр".

Individualized Transition Plan

It is a "curriculum" for children with special needs to go

from pre-school to primary school, from primary school to middle school and from middle school to high school. There is also a “training program” designed to prepare high school students for post graduate life and provide them with career guidance.



111. Эрт илрүүлэлт

Хүүхдийн тусгай хэрэгцээ болон хөгжлийн хоцрогдлыг аль болох эрт илрүүлж, эмчилгээ, сэргээн засал, сургалтын үйл ажиллагааг бага насанд нь буюу 3 хүртэлх насанд нь эхлүүлэх үйл ажиллагаа.

Early screening

Early detection of children’s disabilities and developmental delays and initiation of treatment, rehabilitation and training activities at an early age or up to 3 years of age.

112. Эрт оролцоо

Хүүхдийн тусгай хэрэгцээг илрүүлж, хөгжлийн бүрэн хоцрогдолтой болох эрсдэлийг бууруулах, тэднийг бүрэн чадамжаар нь хөгжүүлж ажиллаж, амьдрах чадвартай бие хүн болгон бэлтгэхэд чиглэгдсэн цогц арга зүй, хөтөлбөр юм.

Early intervention

It is a comprehensive methodology and program aimed at identifying children with disabilities, completely reducing the risk of disability, developing them to their full potential and preparing them to be able to cope and and live as individuals.

Я

113. Ялгаварлан гадуурхах

Чадвар алдалттай, хөгжлийн онцлогтой хүүхдүүдийг бусдаас салангид байлгах буюу эзэнгүй зөнд нь орхих боловсролын хандлага.

Exclusion

Educational tendencies to isolate or abandon children with disabilities

114. Ялгаатай байдал:

Энэ нь хүн бүр өвөрмөц гэдгийг ойлгох, хувь хүний ялгаатай байдлыг (арьс өнгө, үндэс угсаа, хүйс, бэлгийн чиг баримжаа, нийгэм, эдийн засгийн байдал, нас, шашин шүтлэг, бие бялдрын чадвар гэх мэт) хүлээн зөвшөөрөх тухай ойлголт юм. Мөн үзэл суртал, итгэл, үнэмшил эсвэл үнэт зүйлс зэргийг хамааруулдаг.

Diversity

Socially, it refers to the wide range of identities, including things like race, ethnicity, gender, age, national origin, religion, disability, sexual orientation, socioeconomic status, education, marital status, language, veteran status, physical appearance, etc. It also involves different ideas, perspectives, and values.

115. Ялгаатай зааварчилгаа

Хүүхэд бүрийн оюуны чадамж, чадавхад нийцүүлэн сургалтын төрөл бүрийн хэв маягийг сонгон сургалтын хөтөлбөрийг боловсруулах, төлөвлөх арга юм. Энэ нь

өөр өөр түвшний гүйцэтгэлтэй сурагчдын суралцахуйд анхаарал хандуулдаг тул ихэнх суралцагчдад ашиг тусаа өгөх болно.

Differentiated instruction

A method of building or designing an education curriculum consisting of a variety of learning styles to suit every child's mental abilities and potential. It can benefit a vast majority of students as it looks after the students who have weaker skills and also the students who are high performing.

Ном зүй

2. Одгэрэл Д., Жаргалмаа Г. (2020) “Тэгш хамруулах боловсролыг дэмжих нь” ADB, IRIM судалгааны тайлан <http://irim.mn/other-reports>
1. Одгэрэл, Д., Намираа, Б. (2018). Тусгай боловсрол, Улаанбаатар, Содпресс
2. Одгэрэл, Д., Нямдорж, Ч. (2022). Тэгш хамруулан сургах боловсролын үндэс, Улаанбаатар, Адмон
3. American psychiatric association (2013). Diagnostic and Statistical Manual of Mental Disorders (DSM–5). Fifth edition
4. Deborah D. Smith (2018) Introduction to Contemporary Special Education, New Horizons, 2nd Edition
5. Giuliani G.J.D., Pierangelo R. (2010) The Educator’s Diagnostic Manual of Disabilities and Disorders (EDM)
6. Pierangelo R., Giuliani J.D. (2007) The Educator’s Manual of Disabilities and Disorders, John Wilwy & Sons, Inc
7. UNESCO (2004) Changing teaching practice, Using curriculum differentiation to respond students’ diversity
8. UNESCO (2009) Towards Inclusive Education for Children with Disabilities: A Guideline. Bangkok.
9. Williams Ph. (1991) The Special Education Handbook, Open University Press
10. WHO (2001) International Classification of Functioning
11. WHO (1998) International Classification of Impairment, Disability and Handicap